



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/176

Мөрөн сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдыг мэдээллээр хангах, мал маллах арга ухааныг залуу малчдад түгээн дэлгэрүүлэх зорилготой “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Малчдыг дэмжих аяныг орон нутагтаа үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын 21-ний өдрийн 1/176
дугаар захирамжийн хавсралт

“МАЛЧДЫГ ДЭМЖИХ АНХДУГААР АЯН”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа / Улирал/	Зарцуулах хөрөнгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин үр дүн
1	Малчдын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах	I, II	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Малчдын зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөмж боловсруулсан байна.
2	Илгээлтийн эзэн аян өрнүүлэх	II, III	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Малчдын ахуй амьдралтай биечлэн танилцах мал төллөж буй ачаалал ихтэй үед тодорхой хугацаанд ажилд нь туслах, залуучуудыг уламжлалт мал аж ахуйтай танилцах, туршлага судлах ажлыг зохион байгуулах
3	Өрхийн аж ахуйд шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх	II, III, IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Мал маллах, өрхийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нэмэгдсэн байх
4	Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх	II, III, IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Зохистой дадал нэвтрүүлсэн иргэн аж ахуйн нэгжийн тоо
5	Малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх	II, III	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Малын тэжээлийн ургамал тариалах сонирхолтой малчид иргэдийг дэмжин ажилласан байна.
6	Түүхий эдийн	II, III, IV	ОНТ	Аймгийн	Хариуцлагатай

	гарал үүсэл, мөшгөх системийг тогтворжуулах			ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	нүүдэлчин MNS- 6891:2020 стандартыг шинээр 2-с доошгүй суманд шинээр нэвтрүүлсэн байна.
7	Залуу малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх мал маллах уламжлалт соёлд сургахад ахмад малчдаас зөвлөх үйлчилгээг авах	II, III, IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Ахмад малчдын тэргүүн туршлага, уламжлалт мэдлэгийг, радио телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр олон нийтэд сурталчлах түгээх
8	Орон нутагтаа мал аж ахуйн үйлдвэрлэлийг амжилттай эрхэлж байгаа залуу малчин өрхийн сайн жишээг подкаст, стори хэлбэрээр малчид болон нийгэмд хүргэх, сурталчлах	II, III, IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗДТГ	Орон нутагтаа мал аж ахуйн үйлдвэрлэлийг амжилттай эрхэлж байгаа залуу малчин өрхийн сайн жишээг подкаст, стори хэлбэрээр малчид болон нийгэмд хүргэсэн байна.
9	Малчдыг эрт илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг эрчимжүүлэх	II, III, IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ, ЭМГ, Сумын ЗДТГ, ЭМТ	Малчдын эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдалтыг идэвхжүүлсэн байна.
10	Аяныг үр дүнтэй хэрэгжүүлсэн тэргүүний сум шалгаруулах	IV	ОНТ	Аймгийн ЗДТГ, ХХААГ	Аяныг дүгнэж, тэргүүний сумыг шалгаруулж урамшуулсан байна.